



МОНГОЛ УЛС
ДҮНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 8/420

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "н", Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны A/618 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Уул уурхайн ашигт малтмалын ашиглалт, хайгуулын төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт хүлээн авах, дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, Хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, үйлчилгээ, дэд бүтцийн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө хүлээн авах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны A/618 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлгахаа журам"-ын дагуу тухайн жилийн биелэлтийн хэрэгжилтийг шалгаж, дүгнэлт гарган, тайлангийн хурлыг зохион байгуулж, хэрэгжилтийг тооцон ажиллахыг ажлын хэсэг (Н.Гантулга)-т даалгасугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны A/608 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

488191194

Аймгийн Засаг даргын 2019 оны 12
дугаар сарын 06-ны өдрийн 11...дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ХҮЛЭЭН АВАХ, ДҮГНЭХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Нарийн бичгийн дарга: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар,
газрын хэвлэй, түүний баялгийн ашиглалт,
хамгаалалт, нөхөн сэргээлт хариуцсан мэргэжилтэн
Гишүүд: Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны
хяналтын улсын байцаагч
Сав газрын захирагааны ус ашиглагч хариуцсан мэргэжилтэн
Тухайн сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан байгаль хамгаалагч
Иргэдийн төлөөлөл

АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ХҮЛЭЭН АВАХ, ДҮГНЭХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Сумын Засаг дарга
Нарийн бичгийн дарга: Тухайн сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Гишүүд: Газрын даамал
Тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан байгаль хамгаалагч
Иргэдийн төлөөлөл

Аймгийн Засаг даргын 2019 оны 12
дугаар сарын 06-ны өдрийн 12:00-дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

**ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ,
ДЭД БҮТЦИЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
ХҮЛЭЭН АВАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ажлын хэсгийн ахлагч: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Нарийн бичгийн дарга: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлэй, түүний баялгийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт хариуцсан мэргэжилтэн
- Гишүүд:
Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны ашиглалт, хамгаалалтын асуудал хариуцсан мэргэжилтэн
Тухайн сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан байгаль хамгаалагч
Иргэдийн төлөөлөл

**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ ХҮЛЭЭН АВАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ажлын хэсгийн ахлагч: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Нарийн бичгийн дарга: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлэй, түүний баялгийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт хариуцсан мэргэжилтэн
- Гишүүд:
Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтэн
Сав газрын захиргааны ус ашиглагч хариуцсан мэргэжилтэн
Тухайн сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан байгаль хамгаалагч